

**БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД  
ОРУУЛАХ КОМИССЫН ДҮГНЭЛТ**

2025 оны 02 сарын 17-ний өдөр

Дугаар...

БА-068/2025

Улаанбаатар хот

**Нэг. Удиртгал хэсэг**

Монгол Улсын нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 18 дугаар хороонд баригдсан өндөр төвөгшилтэй ангиллын зорьтой 16 давхар 1 блок, 7 (долоо) автомашины дулаан зогсоолтой, 30 (гуч) ортой цэцэрлэг бүхий үйлчилгээтэй 65 (жаран тав) айлын хүчин чадалтай орон сууцны зориулалттай барилга байгууламжид Засгийн газрын 2021оны 07 дугаар сарын 20 өдрийн 212 дугаар тогтоол, Нийслэлийн засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/503 дугаар захирамжийн шийдвэрээр байгуулагдсан 15 хүний бүрэлдэхүүнтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2025 оны 02 сарын 07-ны өдрөөс эхлэн 1 хоногийн хугацаанд ажиллан тухайн барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийв.

**Хоёр. Ерөнхий мэдээлэл**

2.1. Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний 0013244 огноо 2023.07.31 дугаар;БАЗГ2023/485;


2.2. Барилга байгууламжийн зураг төслийн шифр дугаар ДБ-02/2023;

2.3. Захиалагч: Иргэн Мааньт овог, Отгоо эцэг эхийн нэр, Ганбаатар өөрийн нэр, ЧТ83050118 регистрийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 26 дугаар хороо, Их Монголын гудамж Нарлаг өргөө хотхон, 724 байр, 11 тоот, 99005507 холбоо барих утас, o\_ganbaatar83@yahoo.com цахим хаяг;

2.4. Барилгын ажлын ерөнхий гүйцэтгэгч: Сутайн олхонууд ХХК оноосон нэр, 9011334038 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5562821 регистрийн дугаар, БУ12-130/22 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 12 дугаар хороо, Баян Монгол хороолол, 404-р байр, 31 тоот, 99211273 холбоо барих утас, [batbaatar.astron@gmail.com](mailto:batbaatar.astron@gmail.com) цахим хаяг;

2.5. Барилгын ажлын Туслан гүйцэтгэгч байгууллага: Мөнхчандмань илч ХХК оноосон нэр, 9011307067 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5511194 регистрийн дугаар, барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, 99106051 холбоо барих утас, [munch.c@gmail.com](mailto:munch.c@gmail.com) цахим хаяг;

Мандухтек ХХК оноосон нэр, 9011040100 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 2747618 регистрийн дугаар, барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн



дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 13 дугаар хороо, 2-51, 91914597 холбоо барих утас, [mand.07@gmail.com](mailto:mand.07@gmail.com) цахим хаяг;

Хүчит Шугам ХХК оноосон нэр, 9011863349 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 7011449 регистрийн дугаар, барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 10 дугаар хороо, 17-1, 88105495 холбоо барих утас, [khshugam05@gmail.com](mailto:khshugam05@gmail.com) цахим хаяг;

Буяннэмэх Интер ХХК оноосон нэр, 9011294104 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5494427 регистрийн дугаар, барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 19 дүгээр хороо, 5-36 тоот, 99044471 холбоо барих утас, [BuyannemekhLLC@gmail.com](mailto:BuyannemekhLLC@gmail.com) цахим хаяг;

2.6. Барилга байгууламжийн зураг төсөл зохиогч байгууллага: Дээрэн буйлдинг ХХК оноосон нэр, 9011349018 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5592496 регистрийн дугаар, ЗТ12-515/24 зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 26 дугаар хороо, Баянмонгол хороолол, 412байр, 99092232 холбоо барих утас,

2.7. Барилга байгууламжийн ашиглагч, өмчлөгч байгууллага: Иргэн Мааньт овог, Отгоо эцэг эхийн нэр, Ганбаатар өөрийн нэр, ЧТ83050118 регистрийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 26 дугаар хороо, Их Монголын гудамж Нарлаг өргөө хотхон, 724 байр, 11 тоот, 99005507 холбоо барих утас, [o\\_ganbaatar83@yahoo.com](mailto:o_ganbaatar83@yahoo.com) цахим хаяг;

Орон сууц, нийтийн удирдах аж ахуйн газар оноосон нэр, 9014001026 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 2117118 регистрийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 6 дугаар хороо, Бумцэндийн гудамж, 70111746 холбоо барих утас,

2.8. Барилга байгууламжийн төлөв байдал: **Шаардлага хангасан.**

### Гурав. Дүгнэлтийн хэсэг

✓ Барилга байгууламжийг ашиглалтад оруулах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангасан барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул

□ Барилга байгууламжийг ашиглалтад оруулахаас татгалзах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангаагүй, барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдээгүй, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаагүй тул

- Заасан хугацаанд үүрэг даалгаврын биелэлт хангаагүй тул

3.1. Энэ өндөр төвөгшилтэй ангиллын зорьтой 16 давхар 1 блок, 7 (долоо) автомашины дулаан зогсоолтой, 30 (гуч) ортой цэцэрлэг бүхий үйлчилгээтэй 65 (жаран тав) айлын хүчин чадалтай орон сууцны зориулалттай барилга байгууламж түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийж, барилгын ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсний үндсэн дээр комиссоос ДҮГНЭСЭН нь:

Энэ барилга байгууламжийн барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан гэж үзээд ашиглалтад оруулах нь зүйтэй гэж дүгнэв.

3.2. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах болсонтой холбогдуулан захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч байгууллагуудад даалгах нь:

а) барилга байгууламжийн иж бүрэн баримт бичгийн эх хувийг архивт, үлдэх хувийг ашиглагч буюу өмчлөгч, эзэмшигч байгууллагад ... хоногийн дотор багтаан шилжүүлэх;

б) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаанд ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах болон уг хугацаа дуусгавар болохтой холбоотой хууль тогтоомжид заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

3.3. Ашиглагч байгууллагад:

а) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацааг дуусгавар болгоход оролцох;

б) барилга байгууламжийн хувийн хэргийг хөтөлж эхлүүлэх;

в) барилга байгууламжийн хэвийн ашиглалттай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүгээр даалгаж байна.

3.4. Комиссын акт 4 хуудас, хуралдааны тэмдэглэл 6 хуудас, комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн жагсаалт 30 хуудас материал болон барилга байгууламжийн бичиг баримтын жагсаалт болох ... хуудас материалыг дүгнэлтэд хавсаргаж байна.

### **Дөрөв. Дүгнэлтийн баталгаажуулалт**

4.1. Өндөр төвөгшилтэй ангиллын зорьтой 16 давхар 1 блок, 7 (долоо) автомашины дулаан зогсоолтой, 30 (гуч) ортой цэцэрлэг бүхий үйлчилгээтэй 65 (жаран тав) айлын хүчин чадалтай орон сууцны зориулалттай барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлт гаргасан:

Сонгинохайрхан дүүргийн 18 дугаар хороо,  
Иргэн О.Ганбаатарын захиалгатай, зoorьтой 16 давхар 1 блок, 7 (долоо)  
автомашины дулаан зогсоолтой, 30 (гуч) ортой цэцэрлэг бүхий үйлчилгээтэй  
65 (жаран тав) айлын орон сууцны барилга

Комиссын дарга:  
Хяналт шалгалтын газрын  
барилга байгууламжийн ашиглалт,  
бүртгэлийн хэлтсийн даргын албан  
үүргийг түр орлон гүйцэтгэгч



(А.Мөнгөн)

Нарийн бичгийн дарга:  
Захиалагч Иргэн

(О.Ганбаатар)

Барилга байгууламжийг ашиглалтанд оруулах комиссын үүрэг  
даалгаврын биелэлтийн хуудасны хамт хүчинтэй.

---o0o---



СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН 18 ДУГААР ХОРОО, ИРГЭН О.ГАНБААТАРЫН  
ЗАХИАЛГАТАЙ, ЗООРЬТОЙ 16 ДАВХАР 1 БЛОК, 7 (ДОЛОО) АВТОМАШИНЫ  
ДУЛААН ЗОГСООЛТОЙ, 30 (ГУЧ) ОРТОЙ ЦЭЦЭРЛЭГ БҮХИЙ ҮЙЛЧИЛГЭЭТЭЙ 65  
(ЖАРАН ТАВ) АЙЛЫН ОРОН СУУЦНЫ БАРИЛГЫГ АШИГЛАЛТАНД  
ОРУУЛАХ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 02 дугаар сарын 07  
хот

Улаанбаатар

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН  
ГАЗАР

Сонгинохайрхан дүүргийн 18 дугаар, Иргэн О.Ганбаатарын захиалгатай, зоорьтой 16 давхар 1 блок, 7 (долоо) автомашины дулаан зогсоолтой, 30 (гуч) ортой цэцэрлэг бүхий үйлчилгээтэй 65 (жаран тав) айлын орон сууцны барилгыг ашиглалтад оруулах комисс 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдөр 13:00 цагт 15 гишүүний бүрэлдэхүүнтэй эхэлж 15:00 цагт дуусав.

**Комиссын хуралд:**

- |  |               |
|--|---------------|
| 1. Хяналт шалгалтын газрын барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч   | А.Мөнгөн      |
| 2. Хяналт шалгалтын газрын Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтсийн барилгын техникийн хяналтын улсын байцаагч | Н.Ёндонсамбуу |
| 3. Хяналт шалгалтын газрын Дэд бүтцийн стандарт хяналтын хэлтсийн Эрчим хүчний хяналтын улсын ахлах байцаагч               | З.Очирпүрэв   |
| 4. Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК<br>Техник хяналтын ахлах инженер   | Б.Дашдорж     |
| 5. Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК<br>Техник хяналтын ахлах инженер  | Э.Ундрахцогт  |
| 6. Ус сувгийн удирдах газар<br>Хэрэглэгчдэд үйлчлэх албаны шинэ хэрэглэгчдэд үйлчлэх албаны менежер                        | Г.Үүрийнгэгээ |
| 7. Мэдээлэл холбоо сүлжээ ТӨХК<br>Технологийн удирдлага төлөвлөлтийн газар Дэд бүтэц төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн     | Э.Уранчимэг   |
| 8. Онцгой байдлын ерөнхий газар<br>Барилгын зураг төсөл техникийн гүйцэтгэл хариуцсан ахлах мэргэжилтэн, Дэд хурандаа      | Ч.Артаг       |
| 9. Барилгын хөгжлийн төв<br>Барилгын хөгжлийн төвийн Норм, нормативын хэлтсийн мэргэжилтэн                                 | Б.Жаргал      |
| 10. Үндэсний төв архив<br>Зураг төслийн баримтын архивын ахлах архивч  | Э.Шижиртуяа   |
| 11. ОСНААУГ,<br>Баруун түгээх төвийн дулаан хангамжийн инженер   | Ц.Чинзориг    |
| 12. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг хамгаалах  |               |

Байгууллага Хүртээмжийн үнэлгээний ажилтан  
13. Захиалагч Иргэн  
14. Ерөнхий гүйцэтгэгч Сутайн олхонууд ХХК-ийн захирал  
15. Зураг төсөл Дээрэнбуйлдинг ХХК-ийн архитектор

Ч.Уранчимэг  
О.Ганбаатар  
Б.Бямбадорж  
Г.Дашням

#### ИРЦИЙН БАЙДАЛ

- Мэдэгдэл хүлээн авсан – 15
- Хуралд оролцож санал гаргасан – 15

#### ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Сонгинохайрхан дүүргийн 18 дугаар, Иргэн О.Ганбаатарын захиалгатай, зоорьтой 16 давхар 1 блок, 7 (долоо) автомашины дулаан зогсоолтой, 30 (гуч) ортой цэцэрлэг бүхий үйлчилгээтэй 65 (жаран тав) айлын орон сууцны барилга байгууламжийг ашиглалтанд оруулах шаардлага хангасан эсэхийг хэлэлцэх

#### СОНССОН НЬ:

Комисст ажилласан гишүүд барилга байгууламжийн зураг төсөл, баримт бичиг, барилгын ажлын гүйцэтгэлийг хянаж танилцаад дараах саналуудыг гаргав.

Хяналт шалгалтын газрын барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч **А.Мөнгөн:**

- Зохиогчийн дүгнэлтийг шинэчилж ирүүлэх
- Зохиогч айлуудын хаалга мөргөлдөж байгаад тайлбар ирүүлэх
- Лифтны хажууд унтлагын өрөө төлөвлөсөн байна. дуу хэмжилт хийлгэж, тайлбар ирүүлэх
- Барилгын тухай хуулийн дагуу ерөнхий гүйцэтгэгч чанарын баталгаа гаргах
- Ерөнхий төлөвлөгөөнд тайлбар ирүүлэх
- Дүрмийн 8.1-ийг баримтлах

Хяналт шалгалтын газрын Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтсийн барилгын техникийн хяналтын улсын байцаагч **Н.Ёндонсамбуу:**

- Лифтны албан шаардлага биелэлтийн хамт үзүүлэх
- Бетоны лабораторийн шинжилгээ үзүүлэх
- Барилгын тухай хуулийн дагуу баталгаа албан тоот ирүүлэх /14.3 14.6/
- Техникийн давхарын ус зайлууллах хоолойг доош нь буулгах
- Дээврийн ус зайлуулсан хог шүүгч хийх
- Өөрчлөлтийн зураг хийж баталгаажуулах
- Хаалга шүргэлцэж байгаад тайлбар албан тоот ирүүлэн цаашид арга хэмжээ авах
- Лифтны хажууд унтлагын өрөө төлөвлөсөнд тайлбар албан тоот ирүүлж цаашид арга хэмжээ авах
- Тагтгүй байгаа айлд тайлбар албан тоот өгөх

Хяналт шалгалтын газрын Дэд бүтцийн стандарт хяналтын хэлтсийн Эрчим хүчний хяналтын улсын ахлах байцаагч **З.Очирпүрэв:**

- Гадна худаг цэвэрлэх шат бөхлөн



- Узелийн хэрэглээний халуун усны насос солих, дуу чимээ багасгах
- Узелийн агаар сэлгэлтийн шугам тоноглол угсрах
- Алчуур хатаагчны төгсгөлд хий авагч угсрах
- Агаар сэлгэлт ХХУ,ГД, ХАС-ын шугам сүлжээний тоног төхөөрөмжийн угсралт, сорилт туршилтын актуудыг үнэн зөв бүрэн бөглөж баталгаажуулах

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтанд авах саналтай байна.

Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК, Техник хяналтын ахлах инженер

**Б.Дашдорж:**

- Гадна цахилгааны гүйцэтгэлийн холбогдох бичиг баримтыг шалгуулах
- Гадна цахилгааны дэд өртөөны өргөтгөлийн ажлаас буусан хуучин трансформаторийг хүлээлгэн өгсөн акт шалгуулах
- Тоолуур хэмжих хэрэгслийн холболт шалгуулж лац тавиулах
- Зөвшөөрөлгүй цахилгаан эрчим хүчээр хангагдсан үүнд улсын байцаагчийн хариуцлага тооцуулах
- Түр тэжээлийн төлбөр тооцоогүй гэсэн лавлагаа авах
- 0.4кв-ын ерөнхий шийтэнд хаяг, виркжүүлэлт хийх

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтанд авах саналтай байна.

Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК, Техник хяналтын ахлах инженер

**Э.Ундрахцогт:**

- Гадна дулааны худаг цэвэрлэж шат бэхэлж худаг доторх шугам будаж дулаалах
- Узелийн халаалтын насос, ХХУ насос дуу чимээ багасгаж хэвийн болгох
- Узелийн тоноглолын дулаалгын бүрэн хийх
- Хими ус цэвэрлэгээний төхөөрөмжийг залгаж ажилд оруулах
- Нэмэтл усны шугам дээр соронзон хаалт тавьж даралтын дачиктай холбож ажилд оруулах
- Дотор системд тохируулга хийж халахгүй байгаа хэрэгслүүдийг халаах
- Үйлчилгээний төвийн ариун цэврийн өрөөний тоноглолыг суурьлиулах

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтанд авах саналтай байна.

Ус сувгийн удирдах газар, Хэрэглэгчдэд үйлчлэх албаны шинэ хэрэглэгчдэд үйлчлэх албаны менежер **Г.Үүрийнгэгээ:**

- Гадна худагт байгаа өмнө түр ус авч байсан шугамыг бүрэн тасалж, түр усны тоолуурын
- заалтаар төлбөр тооцоог дуусгаж шалгуулах
- Нөөцийн савны хэмжээг багасгасан тул тайлбар, тооцоо дүгнэлт ирүүлэх
- Нөөцийн савны угаалга халдваргүйжүүлэлтийг тусгай зөвшөөрөлтэй байгууллагаар хийлгэж
- акт үйлдэж шалгуулах бусад тоноглол холболтыг Гүйцээх
- Угаалга хийсний дараа сорьц өгч дүгнэлт шалгуулах
- Бохир усны худгыг шалгуулах
- Зоорийн давхарт зургийн дагуу трап хийх, насос суурьлиулах

- Тоолуурын дараах сосонк таслах
- Үйлчилгээний хэсэг буюу 30-н ортой цэцэрлэгийн үйл ажиллагаа явуулахгүй талаар тайлбар
- баталгаа бичиг ирүүлэх

ШАЛГА  
ГАЗАР

ламжийг  
лах коми

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтанд авах саналтай байна.

Мэдээлэл холбоо сүлжээ ТӨХК, Технологийн удирдлага төлөвлөлтийн газар Дэд бүтэц төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн **Э.Уранчимэг:**

- Давхаруудын самбаруудыг цэгцлэж сүлжээний утасыг хаягжуулах
- 2-р давхарт хосолсон разетик суурьлуулах
- Зарлан мэдээлэх системийн микрофоныг хамгаалалтын тавиар дээр байршуулах
- Гадна холбооны худгийг ил гаргах
- Гадна холбоо болон дотор холбооны ажлын актыг хавсаргах

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтанд авах саналтай байна.

Онцгой байдлын ерөнхий газар, Барилгын зураг төсөл техникийн гүйцэтгэл хариуцсан

ахлах мэргэжилтэн, Дэд хурандаа **Ч.Артаг:**

- Галын дотор усны даралтад цэгийн холбох тотгыг дүгнэлтийн дагуу солих /богданов/ төрлийн 51мм
- Барилгын гадна дулаалгын материалыг ГСҮ хүрээлэнд өгч дүгнэлт гаргуулах
- Гал тусгаарлах хамгаалалт зай хэмжээ бичиг баримт үзүүлэх
- Батлагдсан зураг төсөлд өөрчлөлт орсон байна. Гүйцэтгэлийн зураг гаргах
- БНБД 31-01-10 орон сууцны барилгын зураг төсөл төлөвлөлт 5.4 дэх заалтын дагуу тагт хийгдээгүй байна зохиогч тайлбар албан бичиг өгөх
- Тагтны шат засах
- Зоорийн давхарт өөрчлөлт орсон байна. Гүйцэтгэлийн зураг гаргах авто зогсоолд дугуй хязгаарлагч болон 21-05-10 дагуу бие даасан гал унтраах систем төлөвлөх
- Өгсөн үүрэг даалгаврыг албан бичиг болон фото зургаар өгөх

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтанд авах саналтай байна.

Барилгын хөгжлийн төв, Барилгын хөгжлийн төвийн Норм, нормативын хэлтсийн мэргэжилтэн **Б.Жаргал:**

- Барилгын тухай хуулийн дагуу норм нормативийн санд төлбөр төлөх
- Дээврийн парпедны малгай төмөр буруу хийгдсэнийг 0.8мм ээс багагүй зузаантай цайрцан гөлмөн төмрөөр хийх
- 2-р давхарт байрлах цэцэрлэгийн ангид албадан мотортой салхивчийн систем хийгдсэн байгаад тайлбар ирүүлэх
- Барилгын материалын гарагл үүслийн гэрчилгээг шалгуулах
- Орон сууцны өрөөнүүдэд хулсан хавтан хийгдсэнд галын дүгнэлт ирүүлэх

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтанд авах саналтай байна.

Үндэсний төв архив, Зураг төслийн баримтын архивын ахлах архивч **Э.Шижиртуяа:**

- Ил тод ажлын актыг бүрэн бүрдүүлэх, баталгаажуулах, ажлын явцад авсан гэрэл зургийн бичвэр уншигдахгүй байгааг шинэчилж гаргах, гэрэл зурагт тайлбар хийх
- Барилга угсралтын ажлыг гүйцэтгэсэн тэмдэглэлд гүйцэтгэгч байгууллагад баталгаа гаргах
- Архивт бичиг баримт хүлээлгэн өгөх зийтлэг жагсаалтын дагуу баримт бичгийг бүрэн бүрдүүлэх, баримт бичгийн хуудас дугаарлах дотоод төвийг үйлдэх
- Баримт бичиг, болон ажлын зургийн эх хувийг архивт хүлээлгэж өгөх

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтанд авах саналтай байна.

Орон сууц, нийтийн аж ахуйн удирдах газар, Баруун түгээх төвийн дулаан хангамжийн инженер **Ц.Чинзориг:**

- Хэрэглээний халуун усны насос солих
- Халаалтын насносны дуу чимээг засварлаж солих
- Халаалт халуун усны контроллертыг хэвийн ажиллагаанд оруулах
- Узелийн дулаалга хийх
- Гадна шугам сүлжээний зураг зааг эзэмшлийг тодорхойлсон бичиг баримт, шахалт угсралтын актын 1%-ийг өгөх
- Ус сувгийн удирдах газрын холболт цэг өөрчилж хийгдсэний дараа хүлээн авах

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтанд авах саналтай байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг хамгаалах байгууллага **Ч.Уранчимэг:**

- Гадна налуу зам стандарт зориулалтын дагуу болгох
- Автомашины зогсоолд ХБН тэмдэглэгээ хийх
- Үйлчилгээний газрын ариун цэврийн өрөөнд зориулалтын стандарт тоноглол бариул хийх.

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтанд авах саналтай байна.

Захиалагч Иргэн **О.Ганбаатар:**

- Комиссын гишүүдийн өгсөн үүрэг даалгаврыг цаг тухайд нь хурдан шуурхай чанартай хийж гүйцэтгэх болно.

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтанд өгөх саналтай байна.

Сутайн олхонууд ХХК-ны захирал **Б.Бямбадорж:**

- Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтанд авах саналтай байна.

Дээрэнбуйлдинг ХХК-ны архитектор **Г.Дашням:**

- Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтанд авах саналтай байна.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Сонгинохайрхан дүүргийн 18 дугаар, Иргэн О.Ганбаатарын захиалгатай, зоорьтой 16 давхар 1 блок, 7 (долоо) автомашины дулаан зогсоолтой, 30 (гуч) ортой цэцэрлэг бүхий үйлчилгээтэй 65 (жаран тав) айлын орон сууцны барилга байгууламжийг комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулахаар шийдвэрлэв.

Танилцсан:

Хяналт шалгалтын газрын  
барилга байгууламжийн ашиглалт,  
бүртгэлийн хэлтсийн даргын албан  
үүргийг түр орлон гүйцэтгэгч



(А.Мөнгөн)

Тэмдэглэл хөтөлсөн:  
Захиалагч Иргэн

(О.Ганбаатар)